



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/005/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naramchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatar.e@audit.gov.mn Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ Утас: 261885 Цахим хаяг: bat-ErdeneS@audit.gov.mn Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

МАЛ АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСГИЙН
ЭРГЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Л.БАЯРТУЛГА ТАНАА

2025. 03. 21 № 07/1144
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөрийн үлдэгдлээр тайлагнаагүй 2022 он, 2023 оны гэрээний төлбөрт 747,168.2 мянган төгрөгийг шилжүүлсэн, тайлант онд залруулан бүртгэсэн 447,459.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- 2020-2023 оны хооронд нийт 18,319,348.9 мянган төгрөгийн гэрээт ажлын санхүүжилт олгосныг урьдчилж гарсан зардалд хуримтлуулан бүртгэсэн ба 2023 оны жилийн эцэст 6,926,125.9 мянган төгрөгийг урсгал зардал руу хаасан ажил, гүйлгээний баримт нь тодорхойгүй, 2023 оны жилийн эцэст 3,408,970.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж, 2024 оны зарцуулалтыг хянаж бүртгээгүй, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд 247,322 ам доллар буюу 845,347.0 мянган төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд “Үнэн ба зөв байх”, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь Дэлхийн банкны 30,000.0 мянган ам долларын зээлийн эх үүсвэрээр 4 бүрэлдэхүүн арга хэмжээг 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр 2020 оноос үйл ажиллагаа хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2025 оны 6 дугаар сард дуусах ба төслийн зарцуулалт 78.2 хувийн биелэлттэй 25,501.4 мянган ам.долларын санхүүжилт авч 23,454.9 мянган ам доллар буюу 70,461,947.6 мянган төгрөгийн зарцуулалт тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Мал сүргийн бүтээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд махны чиглэлийн 325 толгой малыг худалдан авч Малын удмын сангийн үндэсний төвд хүлээлгэн өгч, иргэн, аж ахуйн нэгжид 3 жилийн хугацаанд түрээсийн гэрээгээр ашиглуулж, малчид өөрсдийн цөм сүргийг бүрдүүлэх боломж бүрдэж байна.

Бусад асуудал

Төслийн хоёрдугаар бүрэлдэхүүн хэсгийн “Шинэлэг шийдэл” хөтөлбөрийн хүрээнд Бүтээмжит түншлэлийн гүйцэтгэлд суурилсан төслөөр 35 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран 18,501,853.6 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 10,369,056.4 мянган төгрөгийн хэрэгжилттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,925,530,074.67	12,296,220,608.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,195,018,022.79	7,001,337,052.13
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	6,195,018,022.79	7,001,337,052.13
31210	Төгрөг	421,299,977.05	1,104,327,140.27
31211	Төрийн сангийн харилцах	421,299,977.05	1,104,327,140.27
31220	Гадаад валют	5,773,718,045.74	5,897,009,911.86
31221	Төрийн сангийн харилцах	5,773,718,045.74	5,897,009,911.86
33	АВЛАГА	602,000.00	240,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	602,000.00	-
33500	Бусад авлага	-	240,000.00
33510	Байгууллагаас авах авлага	-	240,000.00
34	УРЬДЧИЛГАА	3,408,970,441.48	3,408,970,441.48
34600	Урьдчилж гарсан зардал	3,408,970,441.48	3,408,970,441.48
35	БАРАА МАТЕРИАЛ	320,939,610.40	1,885,673,114.45
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	320,939,610.40	1,885,673,114.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	451,771,925.21	312,063,477.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	451,771,925.21	312,063,477.04
39200	Биет хөрөнгө	366,589,525.67	306,132,786.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	497,300,000.00	497,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(142,001,250.00)	(191,731,250.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	94,864,165.00	94,864,165.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(83,573,389.33)	(94,300,128.94)
39300	Биет бус хөрөнгө	85,182,399.54	5,930,690.98
39301	Программ хангамж	266,255,627.00	266,255,627.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(181,073,227.46)	(260,324,936.02)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,377,301,999.88	12,608,284,085.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	447,699,049.94
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	447,699,049.94
41300	Өглөг	-	447,699,049.94
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	240,000.00
41360	Бусад өглөг	-	447,459,049.94
41361	Байгууллагад төлөх өглөг	-	447,459,049.94
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,377,301,999.88	12,160,585,035.16
51	Засгийн газрын хувь оролцоо	10,377,301,999.88	12,160,585,035.16
51200	Хуримтлагдсан үр дүн	10,377,301,999.88	12,160,585,035.16
51210	Өмнөх үеийн үр дүн	18,434,690,393.99	10,377,301,999.88
51220	Тайлант үеийн үр дүн	(8,057,388,394.11)	1,783,283,035.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,377,301,999.88	12,608,284,085.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,144,983,281.00	14,669,604,472.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,144,983,281.00	14,669,604,472.76
120	Нийтлэг татварын бус орлого	8,144,983,281.00	14,669,604,472.76
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,049,224,716.51	12,424,227,351.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,049,224,716.51	12,410,422,576.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,049,224,716.51	12,410,422,576.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,610,434.78	608,996,745.02
210101	Үндсэн цалин	432,610,434.78	608,996,745.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,723,066.09	76,124,593.13
210201	Тэтгэврийн даатгал	53,723,066.09	52,530,893.13
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,898,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,949,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,949,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	11,796,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,960,000.00	69,086,480.18
210304	Байрны түрээс	84,960,000.00	69,086,480.18
2104	Хангамж, бараа материалын зардал	26,338,112.88	18,629,067.57
210401	Бичиг хэрэг	6,595,938.18	4,392,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	4,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,115,424.70	5,240,651.57
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,626,750.00	4,595,916.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,805,900.00	11,420,900.00
210604	Урсгал засвар	5,805,900.00	11,420,900.00
2107	Томилолт, зочны зардал	22,417,400.00	62,503,000.00
210702	Дотоод албан томилолт	22,417,400.00	62,503,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,260,734,547.22	11,418,445,342.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,255,313,943.22	11,394,494,196.03
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,600,000.00	14,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	8,549,760.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	478,672.00	491,572.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,341,932.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	509,814.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	162,635,255.54	145,216,448.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,921,740.00	5,508,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	160,713,515.54	139,708,448.17
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	13,804,775.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	13,804,775.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	95,758,564.49	2,245,377,121.05
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,153,146,958.60	462,094,085.77
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	56,352,943.22	14,635,035.83
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	8,096,794,015.38	447,459,049.94
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(8,057,388,394.11)	1,783,283,035.28

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,449,530,000.00	14,670,206,472.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,449,530,000.00	14,670,206,472.76
120	Нийтлэг татварын бус орлого	3,449,530,000.00	14,670,206,472.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,448,530,000.00	14,669,604,472.76
120009	Бусад орлого	1,000,000.00	602,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	964,350,274.83	12,270,714,128.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	964,350,274.83	12,270,714,128.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	964,350,274.83	12,270,714,128.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,610,434.78	608,996,745.03
210101	Үндсэн цалин	432,610,434.78	608,996,745.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,723,066.09	76,124,593.13
210201	Тэтгэврийн даатгал	53,723,066.09	52,530,893.13
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,898,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,949,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,949,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	11,796,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,960,000.00	69,086,480.18
210304	Байрны түрээс	84,960,000.00	69,086,480.18
2104	Хангамж, бараа материалын зардал	26,338,112.88	18,629,067.57
210401	Бичиг хэрэг	6,595,938.18	4,392,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	4,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,115,424.70	5,240,651.57
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,626,750.00	4,595,916.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,805,900.00	11,420,900.00
210604	Урсгал засвар	5,805,900.00	11,420,900.00
2107	Томилолт, зочны зардал	23,019,400.00	62,503,000.00
210702	Дотоод албан томилолт	23,019,400.00	62,503,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	334,608,573.08	11,418,445,342.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	329,187,969.08	11,395,004,010.63
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,600,000.00	14,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	8,549,760.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	478,672.00	491,572.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,341,932.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,284,788.00	5,508,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,339,788.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	945,000.00	5,508,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,485,179,725.17	2,399,492,344.22
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	320,939,610.40	1,578,538,279.05
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	320,939,610.40	1,578,538,279.05
2200	Дотоод эх үүсвэрээр	320,939,610.40	1,578,538,279.05
221001	Их засвар	320,939,610.40	1,578,538,279.05
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(320,939,610.40)	(1,578,538,279.05)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(56,352,943.22)	(14,635,035.83)

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	56,352,943.22	14,635,035.83
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	56,352,943.22	14,635,035.83
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,107,887,171.55	806,319,029.34
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,087,130,851.24	6,195,018,022.79
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,195,018,022.79	7,001,337,052.13

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	18,434,690,393.99	18,434,690,393.99
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	18,434,690,393.99	18,434,690,393.99
9	Тайлант үеийн үр дүн	-	(8,057,388,394.11)	(8,057,388,394.11)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	10,377,301,999.88	10,377,301,999.88
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	10,377,301,999.88	10,377,301,999.88
19	Тайлант үеийн үр дүн	-	1,783,283,035.28	1,783,283,035.28
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	12,160,585,035.16	12,160,585,035.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,377,000,000.00	13,849,252,407.59	527,747,592.41	96.3
УРСГАЛ ЗАРДАЛ	12,359,000,000.00	12,270,714,128.54	88,285,871.46	99.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,359,000,000.00	12,270,714,128.54	88,285,871.46	99.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	610,000,000.00	608,996,745.03	1,003,254.97	99.8
Үндсэн цалин	610,000,000.00	608,996,745.03	1,003,254.97	99.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,197,000.00	76,124,593.13	4,072,406.87	94.9
Тэтгэврийн даатгал	54,323,300.00	52,530,893.13	1,792,406.87	96.7
Тэтгэмжийн даатгал	6,468,400.00	5,898,400.00	570,000.00	91.2
ҮОМШӨ-ний даатгал	3,234,200.00	2,949,200.00	285,000.00	91.2
Ажилгүйдлийн даатгал	3,234,200.00	2,949,200.00	285,000.00	91.2
Эрүүл мэндийн даатгал	12,936,900.00	11,796,900.00	1,140,000.00	91.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,000,000.00	69,086,480.18	913,519.82	98.7
Байрны түрээс	70,000,000.00	69,086,480.18	913,519.82	98.7
Хангамж, бараа материалын зардал	24,500,000.00	18,629,067.57	5,870,932.43	76.0
Бичиг хэрэг	6,800,000.00	4,392,500.00	2,407,500.00	64.6
Тээвэр, шатахуун	6,000,000.00	4,400,000.00	1,600,000.00	73.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,600,000.00	5,240,651.57	1,359,348.43	79.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,100,000.00	4,595,916.00	504,084.00	90.1
Эд хогшил, урсгал засварын зардал	11,750,000.00	11,420,900.00	329,100.00	97.2
Урсгал засвар	11,750,000.00	11,420,900.00	329,100.00	97.2
Томилолт, зочны зардал	62,503,000.00	62,503,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	62,503,000.00	62,503,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,425,050,000.00	11,418,445,342.63	6,604,657.37	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,401,000,000.00	11,395,004,010.63	5,995,989.37	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	14,400,000.00	600,000.00	96.0
Даатгалын үйлчилгээ	8,550,000.00	8,549,760.00	240.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	491,572.00	8,428.00	98.3
Бараа үйлчилгээний бусад зардал	75,000,000.00	5,508,000.00	69,492,000.00	7.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	75,000,000.00	5,508,000.00	69,492,000.00	7.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,018,000,000.00	1,578,538,279.05	439,461,720.95	78.2
Их засвар	2,018,000,000.00	1,578,538,279.05	439,461,720.95	78.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,377,000,000.00	14,669,604,472.76	(292,604,472.76)	102.0

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,377,000,000.00	14,669,604,472.76	(292,604,472.76)	102.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,377,000,000.00	14,669,604,472.76	(292,604,472.76)	102.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	15	14	1	93.3
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100.0
Үйлчлэх ажилтан	4	3	1	75.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 2,389,050.0 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлангийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн 2,388,810.0 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	2,388,810.0	1	2,388,810.0	-	-	1	2,388,810.0	-	-
Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үлдэгдлийг тайлагнаагүй, хуримтлагдсан үр дүнг бүртгэх баганад үр дүнг тайлагнаагүй	1	-	1	-	-	-	1	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан маягтаар гаргаагүй, төсвийн гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулсан зөрүүг төгрөг мөнгөөр тайлагнаагүй	1	-	1	-	-	-	1	-	-	-
Санхүүгийн тайланд 240.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнасан	1	240.0	-	-	1	240.0	1	240.0	-	-
Ажилтнуудын цалингийн тооцоололд хувь хүний орлогын албан татварын тооцоолол хийхдээ татварын хөнгөлөлт тооцоогүй	1	-	1	-	-	-	1	-	-	-
Дүн	5	2,389,050.0	4	2,388,810.0	1	240.0	5	2,389,050.0	0	0.0

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3.2 Аудитаар нийт 4,629,443.7 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 4,603,597.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 25,846.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд өр төлбөр бүртгэгдээгүй байхад 15 харилцагчид 747,168.2 мянган төгрөгийг 2022 он, 2023 оны гэрээний үлдэгдэл төлбөрт шилжүүлсэн, тайлант онд өр төлбөрөөр залруулан бүртгэсэн 4 харилцагчийн 447,459.0 мянган төгрөгийн үлдэгдлүүдийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	1,194,627.2	-	-	1	1,194,627.2	-	-	-	-
2020-2023 оны хооронд нийт 18,319,348.9 мянган төгрөгийн гэрээт ажлын санхүүжилт олгосныг урьдчилж гарсан зардалд хуримтлуулан бүртгэсэн ба 2023 оны жилийн эцэст 6,926,125.9 мянган төгрөгийг урсгал зардал руу хаасан ажил, гүйлгээний баримт нь тодорхойгүй, 2023 оны жилийн эцэст 3,408,970.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж, 2024 оны зарцуулалтыг хянаж бүртгээгүй, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд 247,322 ам доллар буюу 845,347.0 мянган төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	3,408,970.4	-	-	1	3,408,970.4	-	-	-	-
Ажил гүйлгээг бүртгэхдээ тооцооны данс хөтлөөгүй, аккруэл сууриар бүртгээгүй байна	1	-	-	-	1	-	-	-	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Төсөл 2025 оны 6 дугаар сард дуусах гэрээтэй байтал төслийн зарцуулалт 78.2 хувийн биелэлттэй өссөн дүнгээр 23,454.9 мянган ам доллар буюу 70,461,947.6 мянган төгрөг байна. Нийт зарцуулалтын 42.4 хувь буюу 29,899,031.1 мянган төгрөгийг бараа, ажил үйлчилгээ, бүтээмжит түншлэлийг хөгжүүлэхэд, 35.1 хувь буюу 24,685,903.6 мянган төгрөгийг зөвлөх болон үйл ажиллагааны зардалд, 25.5 хувь буюу 17,984,900.0 мянган төгрөгийг гамшгийн үед хариу арга хэмжээ авах зориулалтаар малчин өрх бүрд 100.0 мянган төгрөг олгоход зарцуулсан байгаагаас харахад төслийн бодит үр дүн хангалтгүй, үр ашиг багатай байна гэж үзлээ.	1	-	-	-	-	-	1	-	-	-
Гэрээний төлбөрт 27 иргэнд 206,768.0 мянган төгрөгийг олгоходоо 25,846.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцож тайлагнаагүй байна.	1	25,846.0	-	-	-	-	1	25,846.0	-	-
Дүн	5	4,629,443.6	0	0.0	3	4,603,597.6	2	25,846.0	0	0.0

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 14,580,916.6 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 4,872,234.2 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 3,474,956.6 мянган төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 6,233,725.8 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаа болоогүй 5 мэдээлэл, хугацаанд нь оруулсан 163 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 2,625,610.0 мянган төгрөгийн орлого, 12 удаагийн 2,246,624.2 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг мэдээллээгүй мөн 3 удаагийн 7,103,992.2 мянган төгрөгийн орлого, 18 удаагийн 2,964,778.4 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд хугацаа хоцорч мэдээлсэн байна.	1	4,872,234.2	1	4,872,234.2	-	-	-	-
Дүн	1	4,872,234.2	1	4,872,234.2	0	0.0	0	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Өмнөх оны аудитаар "Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2,620,847.7 мянган төгрөгийн 7 худалдан авалт хийгдээгүй нь худалдан авах бараа, ажил, үйлчилгээний суурь судалгаа, техник эдийн засгийн тооцоолол, хэрэгцээ шаардлагын талаарх судалгаа хангалтгүй байсантай холбоотой байна" гэсэн зөрчилд хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй буюу тайлант онд 3,474,956.6 мянган төгрөгийн 15 ажил хийгдээгүй байна.	1	3,474,956.6	-	-	1	3,474,956.6	-	-

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Бүтээмжит түншлэлийн хөтөлбөрөөр хэрэгжиж буй 28 харилцагчтай байгуулсан 18,501,853.6 мянган төгрөгийн гэрээт ажлын үлдэгдэл төлбөр 6,233,725.8 мянган төгрөгийн санхүүжилтийн өр төлбөрийг Сангийн сайдын 2024 оны 01/10803 дугаар тушаалаар түр хойшлуулсан гэсэн шалтгаанаар нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.	1	6,233,725.8	-	-	-	-	1	6,233,725.8
Дүн	2	9,708,682.4	0	0.0	1	3,474,956.6	1	6,233,725.8
Нийт дүн	3	14,580,916.6	1	4,872,234.2	1	3,474,956.6	1	6,233,725.8